



Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар

**ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН ХӨРӨНГӨӨР
ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛИЙН ҮР ДҮН
ХАНГАЛТГҮЙ БАЙНА**

2023 оны 8 дугаар сар

**ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН
ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ҮР ӨГӨӨЖ**

АУДИТЫН КОД: ДГА-2023/25-8-ШТА-ГА

АГУУЛГА:

Товьёг	3
Товчилсон үгийн тайлбар	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	3

**БҮЛЭГ А: ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ ХЭВИЙН БАЙГАА БОЛОВЧ ТӨСЛИЙН ҮР ДҮН
ХАНГАЛТГҮЙ БАЙНА**

А.2 Зээлдэгч гэрээнд заасан үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна

А.2.1. Зээлийг хуваарийн дагуу төлж байгаа хэдий ч төслийн хэрэгжилт хангалтгүй байна	5
---	---

А.2.2. Төслийн үйл ажиллагаа нь орон нутагт хэрэгцээ шаардлагатай байгаа хэдий ч үйл ажиллагааны үр дүн хангалтгүй байна.....	6
---	---

В.2.2. Зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг зохих хууль тогтоомжийн дагуу хүлээн аваагүй, бүртгэж тайлагнаагүй байна.....	7
--	---

Дүгнэлт:	8
----------------	---

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Дорноговь аймагт 2016-2022 онд хөдөө аж ахуйн салбарт хэрэгжсэн төслийн мэдээлэл	5

Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Үхрийн ферм	6
Зураг 2-4	Тоног төхөөрөмж	6

Товчилсон үгийн тайлбар

Товчилсон үг	Тайлбар
ААНБ	Аж ахуй нэгж, байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗБДТ	Зээлийн батлан даалтын сан
ҮАГ	Үндэсний аудитын газар
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”- г тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.
Аудитын зорилт	“Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Засгийн газрын шугамаар авсан зээлийг үр дүнтэй ашиглаж байгаа эсэх; - Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгийн ашиглалт үр өгөөжтэй байгаа эсэх; - Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоо үр нөлөөтэй эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт зээл, тусламжийн хөрөнгөөр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч иргэн, ААНБ-ыг хамруулан гүйцэтгэв.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, Нийцлийн аудитын холбогдох стандартад заасан арга зүйг ашиглан салбарын бодлого, тогтолцоо, үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий хянан удирдаж, аудитын менежер У.Оюунтүлхүүр аудитын стандарт, арга зүйн дагуу хяналт тавьж, ахлах аудитор Л.Равдандорж, аудитор Б.Уранбилэг нар хийж гүйцэтгэв. Аудитыг 2023 оны 05 дугаар сарын 22-нд эхэлж, 8 дугаар сарын 18-ны өдрийн дотор хийж гүйцэтгэлээ. Аудитын тайланг ҮАГ-т хүргүүлэв.
Хүндрэл бэрхшээл	Аудитыг хийж гүйцэтгэхэд орон нутагт шаардлагатай мэдээ, баримт байхгүйгээс хүндрэлтэй байв.
Ерөнхий мэдээлэл	Дорноговь аймагт Азийн хөгжлийн банкны “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилт төсөл”-ийн хөрөнгөөр хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 2020-2021 онд хэрэгжсэн 107.4 сая төгрөгийн 2 төсөл хэрэгжүүлж дууссан байна. Харин Зээлийн батлан даалтын сангаас 2018 онд 240.0 сая төгрөгийн батлан даалт гаргаж, 400.0 сая төгрөгийн 1 төсөл хэрэгжүүлж, одоогийн байдлаар дуусаагүй байна.

БҮЛЭГ А: ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ ХЭВИЙН БАЙГАА БОЛОВЧ ТӨСЛИЙН ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА**А.2 Зээлдэгч гэрээнд заасан үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна****А.2.1. Зээлийг хуваарийн дагуу төлж байгаа хэдий ч төслийн хэрэгжилт хангалтгүй байна**

Дорноговь аймагт Азийн хөгжлийн банкны “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилт төсөл”-ийн хөрөнгөөр хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 2020-2021 онд 107.4 сая төгрөгийн 2 төслийг хэрэгжүүлжээ.

Харин Зээлийн батлан даалтын сангаас 2018 онд 240.0 сая төгрөгийн батлан даалттай хөрөнгө оруулалтын зээлийг гаргаж, Капитрон банкнаас 400.0 сая төгрөгийн 1 төсөл хэрэгжүүлж эхэлсэн нь бүрэн хэрэгжиж дууссан байна. /Хүснэгт №1/

Дорноговь аймагт 2016-2022 онд хөдөө аж ахуйн салбарт хэрэгжсэн төслийн мэдээлэл

/Хүснэгт №1/

Эх үүсвэр	Төслийн нэр	Зориулалт	Хамрах хугацаа	Мөнгөн дүн /сая төгрөг/	Хэрэгжиж дууссан эсэх
“Зээлийн батлан даалтын сан”	Бизнесийн үйл ажиллагаа өргөжүүлэх хөрөнгө оруулалтын зээл	Үхрийн байр, гүний худаг, махны үхрийн хороо барих, саалтуур, сүү хадгалах танк, ачааны хөргөгчтэй машин худалдан авах, сүү, махны чиглэлийн үнээ худалдан авах	2018	240.0	Үгүй
“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилт төсөл	Өвөлжилт хүндэрсэн зарим аймгуудын малчдад хүнсний тусламжийн бараа нийлүүлэх	Дорноговь аймгийн 1000 малчин өрхөд	2021	80.8	Тийм
	Дорноговь аймгийн бэлчээрт уст цэг тогтоох газар доорх усны геофизикийн хайгуулын ажил гүйцэтгэх	Дорноговь аймгийн Их хэт, Дэлгэрэх, Сайншанд, Айраг сумдад 20 бэлчээрт хайгуул хийж уст цэг тогтоох	2020	26.6	Тийм
Нийт				347.4	

Зээлийн батлан даалтын сангаас 2018 онд Капитрон банканд 240.0 сая төгрөгийг олгож, 1 иргэнд үхрийн фермерийн үйл ажиллагаа эрхлэх төслийг хэрэгжүүлэхэд 400.0 сая төгрөгийн зээл гаргажээ. Аудитын явцад төслийн үйл ажиллагаатай танилцахад үйл ажиллагаа нь тогтворжоогүй байна. Энэ нь Ковид-19 цар тахал болон Сайншанд сумын цаг агаарын байдлаас хамаарч фермийн үхрийг сум алгасан шилжүүлсэнтэй холбон тайлбарлаж байна.

Зээлийн эргэн төлөлтийн байдлыг авч үзэхэд 2020-2021 онд 2 удаа хүсэлт өгснөөр ЗБДС-аас үндсэн төлбөрийг 16 сарын хугацаанд бууруулж, хүүгийн төлбөрийг 3 сараар хойшлуулан, 2021 оны 4 дүгээр сараас төлүүлэхээр хуваарьт өөрчлөлт оруулсан байна. Үүний дагуу төлбөрийг хуваарийн дагуу хугацаанд нь төлж, 2023 оны 8 дугаар сарын байдлаар 372.8 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

А.2.2. Төслийн үйл ажиллагаа нь орон нутагт хэрэгцээ шаардлагатай байгаа хэдий ч үйл ажиллагааны үр дүн хангалтгүй байна

ЗБДС-аас 60 хувийн батлан даалттай олгосон нийт 400.0 сая төгрөгийн үхрийн фермерийн үйл ажиллагаа эрхлэх төслийн зориулалтад бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх үхрийн байр, гүний худаг, махны үхрийн хороо барих, саалтуур, сүү хадгалах танк, ачааны хөргөгчтэй машин худалдан авах, сүү махны чиглэлийн үнээ худалдан авахаар тусгажээ. Иргэн зээлийг 2018 оноос 120 сарын хугацаатай авсан байна. Гэтэл аудитын явцад үйл ажиллагаатай танилцахад хэзээ үйл ажиллагаа явуулсан нь тодорхойгүй дараах байдалтай байна. /Зураг №1/



Зээлдэгчтэй холбогдох орон нутагт тогтвортой оршин суудаггүй, зуншлага муу учир фермийн үхрийг оторлосон гэсэн тайлбарыг өгч байна. /Зураг №2-4/



Мөн зээлийн хөрөнгөөр бараа материал, тоног төхөөрөмж, автомашин мал амьтан зэргийг худалдан авсан гэх боловч анхан шатны баримтгүй, мах, сүү худалдан борлуулсан талаарх гэрээ хэлцэл болон бусад холбогдох баримтыг аудитын явцад ирүүлээгүй. Иймд зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг нотлох боломжгүй байна.

B.2.2. Зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг зохих хууль тогтоомжийн дагуу хүлээн аваагүй, бүртгэж тайлагнаагүй байна



ХХААХҮЯ-аас “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилт төсөл”-ийн хөрөнгөөр “Дорноговь аймгийн 20 бэлчээрт уст цэг тогтоох газар доорх усны геофизикийн хайгуулын ажил”-ыг “Эрдэнэдрийлинг” ХХК-аар 26.6 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр 2004/24/05/138 тоот ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, хэрэгжүүлсэн байна.

Геофизикийн хайгуулыг Дорноговь аймгийн Иххэт, Дэлгэрэх, Сайншанд, Айраг сумдын 20 бэлчээрт 4 дүгээр сарын 25-ны өдрөөс 6 дугаар сарын 24-ний өдрийн хооронд гүйцэтгэж өрөмдөх цэгийг тэмдэгжүүлж акт үйлдэн баримт материалыг ажлын үр дүн, тайлан, зураг, уст цэгийн акт, зураг зэрэг баримтын хамт Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүлээлгэн өгсөн байна. Гэтэл хүлээн авсан байгууллага нь бүртгэлд тусгаагүй байна.



Мөн дээрх төслийн хүрээнд ХХААХҮЯ-аас “Өвөлжилт хүндэрсэн зарим аймгуудын малчдад хүнсний тусламжийн бараа нийлүүлэх” 80.8 сая төгрөгийн 1000 багц хүнсний барааг Автотээвэр “ТАВ” ХХК-аар Дорноговь аймагт хүргүүлсэн байна.

Хүнсний тусламжийн барааг аймгийн Засаг даргын 2021 оны А/169 дугаар захирамжаар байгуулагдсан 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хүлээн авсан байна. Гэтэл дээрх 1000 багц тусламжийн барааг хүлээн авахдаа зохих журмын дагуу данс бүртгэлд тусгаагүй, шууд хуваарилсан байгаа нь Нягтлан болох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4¹ дахь заалтыг зөрчсөн байна.

¹ 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ, 14.4.2. бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Азийн хөгжлийн банкнаас 2018-2023 онд тус аймагт 400.0 сая төгрөгийн 1 зээл, 107.4 сая төгрөгийн 2 төслийг хэрэгжүүлсэн байна.
- Аудитын хамрах хугацаанд 107.4 сая төгрөгийн 2 төсөл бүрэн хэрэгжиж дууссан байна.
- ЗБДС-аас 60 хувийг батлан дааж олгосон 400.0 сая төгрөгийн 1 зээлийн эргэн төлөлт хэвийн байгаа ч үйл ажиллагаа нь тогтворжоогүй, төслийн хэрэгжилт хангалтгүй, тоног төхөөрөмж, бараа материал, мал амьтан худалдан авсан анхан шатны баримтгүй, мах, сүү худалдан борлуулах гэрээ хэлцэл, бусад холбогдох баримт байхгүй байна.
- ЗБДС-аас батлан дааж олгосон зээлийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг бүрэн нотлох боломжгүй байна.

Аудитаар нийт 400.0 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, аудитын тайланг Үндэсний аудитын газарт хүргүүллээ.

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД:

ГҮЙЦЭТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

Л.РАВДАНДОРЖ

АУДИТОР



Б.УРАНБИЛЭГ


ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР



У.ОЮУНТҮЛХҮҮР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.